



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 4/31

Мандалговь

Гурвансайхан сумын Цэвэршүүлэх байгууламжийн
лаг зөөх автомашин нийлүүлэх ажлыг хүлээлцэх
комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 4.3.4 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй “Гурвансайхан сумын Цэвэршүүлэх байгууламжийн лаг зөөх автомашин нийлүүлэх” ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Оюунболд (Гүйцэтгэгч)

Гишүүд: Ж.Уянга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
М.Болд (Гурвансайхан сумын цэвэршүүлэх Байгууламжийн ажилтан)

2. Гурвансайхан сумын Цэвэршүүлэх байгууламжийн лаг зөөх автомашин нийлүүлэх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150131